



Шинжээчийн тайлан

Байгууллагын нэр: **Соёл Урлагийн Их Сургуулийн Соёлын Сургууль**

Хөтөлбөрийн нэр: **НОМЫН САН СУДЛАЛ**

Индекс: **D032201**

Шинжээчийн баг:

Ахлагч: Б.Гантулга

Гишүүд: Ч.Мөнх-Эрдэнэ

Д.Дэлгэрмаа

2022 оны 6-р сарын 10-ны өдөр

Агуулга

Товчилсон үгийн тайлбар

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

IV. Уулзалтад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс.

IV. Төгсөгчдийн нэрс

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

VI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

VII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Товчилсон үгийн тайлбар

1. МУ-Монгол улс
2. ОХУ- Оросын холбооны улс
3. БНХАУ-Бүгд найрамдах хятад ард улс
4. БНСУ-Бүгд найрамдах солонгос улс
5. ӨМӨЗО-Өвөр монголын өөртөө засах орон
6. СУИС- Соёл урлагийн их сургууль
7. СС- Соёлын сургууль
8. БСШУЯ- Боловсрол соёл шинжлэх ухааны яам
9. БСШУСЯ- Боловсрол соёл шинжлэх ухаан спортын яам
10. НСС- Номын сан судлал
11. АХБ-Азийн хөгжлийн банк
12. СГДyC - Соёл гэгээрлийн дунд сургууль
13. ШУТС- Шинжлэх ухаан технологийн сан
14. ШУТТНС- Шинжлэх ухаан технологийн төв номын сан
15. ЭЕШ-Элсэлтийн ерөнхий шалгалт
16. ЕБС- Ерөнхий боловсролын сургууль
17. UNIMIS- University management information system- Их сургуулийн удирдлагын мэдээллийн систем
18. БМИҮЗ- Боловсролын Магадлан Итгэмжлэлийн Үндэсний Зөвлөл
19. ТББ- Төрийн Бус Байгууллага
20. CDIO- Conceive Design Implement Operate- Үр дүнд суурилсан боловсролын арга зүй
21. MNS- Mongolian National Standart

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр /Монгол, Англи/	Соёл Урлагийн Их Сургуулийн Соёлын Сургууль
-----------------------------------	---

Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/	НОМЫН САН СУДЛАЛ	
Индекс	D032201	
Шинжээчид	1. Б.Гантулга Их засаг олон улсын их сургуулийн харьяа Дүрслэх урлаг, дизайн технологийн дээд сургуулийн захирал, доктор 2. Ч.Мөнх-Эрдэнэ Удирдлагын академийн номын сангийн эрхлэгч 3. Д.Дэлгэрмаа Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн Боловсрол Судлалын Сургуулийн багш, доктор	
БМИҮЗ-ийн Мэргэжилтэн	Г.Даваажаргал БМИҮЗ-ийн Ажлын албаны магадлан итгэмжлэл хариуцсан мэргэжилтэн, доктор	
Төлөвлөгөө	Он сар өдөр	Хийгдсэн байх ажлууд
		/Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу бичнэ/
	2022.06.02	Сургуулийн орчинтой танилцах
		Багш нартай уулзах
		Оюутнуудын төлөөлөлтэй уулзах
		Сургуулийн бэлтгэсэн материал, илрэл нотолгоотой шинжээчид танилцах
	2022.06.03	Төгсөгчдийн төлөөлөлтэй уулзах /цахимаар/
		Ажил олгогчийн төлөөлөлтэй уулзах /цахимаар/
	Сургуулийн бэлтгэсэн материал, илрэл нотолгоотой шинжээчид танилцах	
	Тайлантай холбоотой нотлох баримттай танилцах, холбогдох хүмүүсээс тодруулга, лавлагаа авах	
	Шинжээчдийн баг магадлан итгэмжлэлийн урьдчилсан дүгнэлтийг байгууллагад мэдэгдэнэ.	
Шалгуур шаардлага /журам/	БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 08 тоот тогтоолоор баталсан “Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам”-ын “Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуур шаардлага”	

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

- Гадаадад номын сангийн мэргэжлээр сургах шийдвэр* 1956 онд гарч Галсангийн Ренчинсамбуу, Магсарын Баянзул, Юмжаагийн Цэнд зэрэг анхны номын сангийн мэргэжилтэн бэлтгэгдсэнээс хойш 30 гаруй хүн төгсжээ.
- Дотооддоо 1960-1962 онд 30 хүн номын сангийн курс төгссөн
- 1973 онд Багшийн сургуулийн дэргэд анхны тусгай дунд боловсролтой номын санчдыг бэлтгэсэн
- 1983 оноос “Соёл гэгээрийн дунд сургууль” байгуулж “Номын санчийн анги”-ийг нээсэн

- 1991 оноос СГДyC-ийг Соёлын коллеж болгож, дипломын дунд, дээд боловсролтой номын санч бэлтгэсэн
- 1994 оноос бакалаврын зэрэгтэй анхны номын санчдыг бэлдэж эхэлсэн.
- 2010 оноос СУИС-тай нийлсэн

“НСС”- хөтөлбөрийн сургалтын хэлбэр

- 1970-1971 оны хичээлийн жилээс номын сангийн ажилтан бэлтгэх өдөр, эчнээ сургалт;
- 2008 оноос интернэтэд суурилсан бакалаврын зайн сургалт;
- 1994 оноос Номын сан судлал хөтөлбөрөөр Магистрын сургалт;
- 1996 оноос “Номын сан судлал, мэдээлэл” чиглэлээр докторын сургалтыг тус тус явуулсан;

“НСС”- хөтөлбөрөөр төгсөгчдийн тоо

- 39 удаагийн төгсөлт хийсэн
- Бакалаврын зэрэгтэй -2452
- Магистрын зэрэгтэй – 70 гаруй
- Докторын (Ph.D) зэрэгтэй -5
- Докторын (Sc.D) зэрэгтэй -1

“НСС”- хөтөлбөр хэрэгжүүлэх орчин

- 1970-д оноос хойш НСС хөтөлбөрийн дагуух ном, сурах бичиг, тогтмол хэвлэл, цахим номоор бүрдүүлсэн тусгай номын сан хөмрөгтэй;
- Лекц, дадлагын хичээлийн цаасан болон цахим иж бүрдэл бүхий тестийн сан, ном, сурах бичиг, файл жилээс жилд улам нэмэгдэж байна.
- 2013 оноос номын сангийн КОХА программыг, 2017 оноос сургалтын бүх талын үзүүлэлт бүхий “Динамик” программын үйл ажиллагаа тогтмолжсон;
- 2018 оноос Зайн сургалтын лаборатори байгуулсан.
- Сургууль нь хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай сургалтын орчин материаллаг болон техник технологийн нөхцөлийг хангалттай бүрдүүлж, тасралтгүй сайжруулан бэхжүүлэх бодлого баримтлан амжилттай ажиллаж байна.

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Илрэл нотолгоо:

- ✓ Нийгэм эдийн засаг, технологи, салбарын хөгжлийн ирээдүйн төлөв, сонирхогч талуудын эрэлт хэрэгцээнд хийсэн STEEP дүн шинжилгээ хийсэн
- ✓ Гадаадын хөтөлбөрүүдтэй харьцуулсан судалгаа, бенчмарк:

№	Хөтөлбөрийн нэр	Ижил хичээл		Кредит
1	СС-ийн “Номын сан судлал” хөтөлбөр	30	42%	72
2	ОХУ-ын Буриадын дорнод Сибирийн Соёл урлагийн их сургууль “номын сан мэдээллийн үйл ажиллагаа” хөтөлбөр	27	43%	69
3	Тайвань улсын их сургууль “Номын сан мэдээллийн шинжлэх ухаан”	31	38%	82
4	Кени улсын Кенятта их сургууль “Номын сан мэдээллийн шинжлэх ухаан”	21	49%	91
Дундаж		27	42%	69

Сургалтын төлөвлөгөөний нийт хичээлүүдийн 90 орчим кредит, мэргэжлийн судлах хичээлүүдийн 69 кредит нь олон улсын хөтөлбөрүүдтэй агуулгын хувьд ижил төстэй байгаа нь сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- “Номын сан судлал” хөтөлбөр нь 1965 оноос үйл ажиллагааны суурь тавигдаж эхэлснээр эдүгээ 60 жилийн туршлага хуримтлуулаад байгаа Монгол улсад анхны мэргэшсэн боловсон хүчин бэлтгэх үеэс хэрэгжиж ирсэн агуулга, арга зүйн арвин туршлага шингэсэн дээд боловсролын салбарын ууган хөтөлбөрүүдийн нэг юм.

Зөвлөмж:

- Хөтөлбөрийг боловсруулахад холбогдох эрх зүйн баримт бичгүүдийн үзэл баримтлалтай холбох, тухайлбал: “Номын сан судлал мэдээлэл” мэргэжилтний стандарт
- Гадаадын их дээд сургуулиудад ижил хөтөлбөрөөр бэлтгэж байгаа “Номын санч” мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөрийг судлан харьцуулах

Commented [U1]:

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Илрэл нотолгоо:

- ✓ Хөтөлбөрийн төгсөгчийн загварыг орчин цагийн номын санчийн ур чадварт суурилан, төгсөгчдийн ур чадварын харьцуулсан судалгаанд үндэслэн боловсруулсан.
- ✓ Хөтөлбөрийн зорилгыг тодорхойлсон баримт бичиг СУИС-ийн алсын хараа болон Соёлын сургуулийн, эрхэм зорилго, чанарын зорилтод үндэслэн хөтөлбөрийн зорилго, зорилт, үнэт зүйлийг тодорхойлсон байгаа нь байгууллагын зорилго, эрхэм зорилттой нийцэж байна.
- ✓ Хөтөлбөрийн зорилгыг тодорхойлох, өөрчлөлтийн талаар олон нийтэд мэдээлэх, төгсөгчдийн эзэмших мэдлэг, ур чадвар, хандлагыг тодорхойлохдоо оролцогч талуудын саналыг тусгадаг, ажил олгогчийн судалгаанд үндэслэсэн.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн зорилго байгууллагын эрхэм зорилготой нийцсэн

Зөвлөмж:

- Хичээлийн хөтөлбөрийн зорилгын оновчтой байдалд өөрийн үнэлгээ хийдэг байх

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- ✓ Сургалтын нэгдсэн төлөвлөгөө, график хөтөлбөрийн /PLO/ болон хичээлийн суралцахуйн үр дүнг /CLO/ 2013 онд Америкийн сэтгэл судлалын нийгэмлэгээс эрхлэн гаргасан загварын дагуу, шаардлагад нийцүүлэн боловсруулсан (APA).
- ✓ Хөтөлбөрийг баталгаажуулахдаа сургалтын хөтөлбөрийн үр дүнд чиглүүлж, агуулга, үр чадварын хувьд харилцан залгамж холбоог ханган, сургалтын арга зүйн болон үнэлгээний олон талт арга хэлбэрийг хэрэглэдэг байна

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Элсэгчдийн тоо цөөрөх болон тухайн тэнхимд багшаар ажиллах боловсон хүчний хангалтгүй байдал үүсээд байгаа боловч хөтөлбөрийн хэрэгжилтийн чанар буураагүй байна.

Commented [U2]: Найруулгыг эргэж харах

Анхаарах асуудал:

- Хичээлийн хөтөлбөрүүдийг тэнхимийн хурлаар хэлэлцэж, батлан шаардлагын дагуу мөрдөн ажиллахад анхаарах
- БШУЯ-ны сайдын 2014 оны 04 сарын 28 өдрийн А/174 тушаалд зааснаар хичээлүүдийн хөтөлбөрийн иж бүрдэл хэсгүүд болох хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүй, хөтөлбөрийн үнэлгээ, хичээлийн тогтмол зэрэг хөтөлбөрийн бүрдэл хэсгүүдийг гүйцэд тодорхойлох
- “Номын сан судлал” мэргэжилтний стандартад заасан мэргэжлийн тодорхойлолт, төгсөгчдийн мэргэжлийн бэлтгэлд тавигдах үндсэн шаардлага, стандартад заасан норматив цагийн багтаамж, сургалтын төлөвлөгөөний цагийн багтаамжид баримжаалах, стандартад заасан багшийн нөөцөд тухайн мэргэжлийн хичээлийг зааж буй багш нарын 70%-аас доошгүй нь үндсэн багш байна гэсэн заалтуудыг хангаж ажиллахад анхаарах
- Хичээлүүдийн стандартууд байхгүй /хичээлүүдийн сэдэвчилсэн төлөвлөгөөг хөтөлбөрийн албаны тамгаар баталгаажуулсан байгаа нь тухай хичээлийн стандарт гэж үзэхгүй/

Commented [U3]: Юу у дутуу байгаа вэ? Түүнийг тодорхой болгох

Commented [U4]: Энэ үг байхгүй байх аа

Зөвлөмж:

- Хичээлийн стандартуудыг боловсруулах
- Хичээлээр хүрэх үр дүн хөтөлбөрөөр хүрэх үр дүнгийн холбоог хичээлийн стандарт болон хөтөлбөрт тусгаж боловсруулах

1- р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Илрэл нотолгоо:

- ✓ Төгсөгчид мэргэжлийн хичээлийн агуулга сайн, төгсөгчдийн төгсөөд ажиллах ажлын байранд шаардлага бүхий мэдлэг чадварыг олж авдаг гэж дүгнэсэн
- ✓ Хичээлүүд хөтөлбөрүүд
- ✓ Хөтөлбөрийн агуулгын болон арга зүйн шинэчлэлт тогтмол хийгддэг

Commented [U5]: Тодорхой нотох баримтуудыг дурдах

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага

- Хөтөлбөрийг судлаад төгссөн оюутны ярилцлагаас төгсөөд ажлын байргүй байна гэсэн асуудал үүсдэггүй хэмээн тодорхойлсон нь уг хөтөлбөрийн хэрэгжилтийн хэрэгцээ их, чанар сайн байгааг гэрчилж байна.

Анхаарах асуудал:

- Оюутан хичээл болон багшаа сонгох боломж бүрдүүлэх
- Сургалтын төлөвлөгөөнд төлөвлөгдсөн хэдий ч сонгогддоггүй сонгоны хичээлд анхаарах
- Сургалтын төлөвлөгөөний нийт 126 кредитэд дадлагын кредит 5 байгаа нь хэр оновчтой вэ? гэдэг анализ хийх

Зөвлөмж:

- Сургалтын төлөвлөгөөний зарим нэг сонгон судлах хичээлүүдийг эргэн харж, суралцагчийн хэрэгцээнд илүү нийцсэн сонгон судлах хичээл оруулахад анхаарах
- Хөтөлбөрийн агуулга шинэчлэлийн талаар мэдээлэл түгээдэг байх

2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Илрэл нотолгоо:

- ✓ Сургалтад ашиглаж буй арга зүй нь мэдлэг бүтээлгэж, хэрэглэж сургахад чиглэдэг, хичээл бүрээр хэрэглэдэг арга зүйн сан байна
- ✓ Мэргэжлийн онцлог хэрэгцээнд нийцсэн дэвшилтэт сургалтын аргуудыг хичээл бүрээр ашигладаг, багш, оюутан хэрэгцээт мэдээллийг сургуулийн вэйбээс шууд харах боломжтой

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Мэргэжлийн хичээлийн онцлог, оюутны цогц чадамжид суурилсан хөтөлбөр боловсруулсан

Анхаарах асуудал:

- Сургалтын арга зүйд анализ хийдэг, өөрийн үнэлгээ хийдэг байхад анхаарах
- Хичээлийн хөтөлбөрт тухайн хичээлийн агуулга, суралцагчдын хувийн болон насны онцлогт нийцсэн арга зүйн хувилбаруудыг бичиж оруулахад анхаарах

Зөвлөмж:

- Тухайн мэргэжлээр богино, дунд, урт хугацааны сургалтын хөтөлбөрүүдийг боловсруулан хэрэгжүүлэх боломжийг эрэлхийлэх
- Сургалтын арга зүйг хэрэгжүүлэх загвар, заавар, зөвлөмж, суралцахуйн болон багшлахуйн арга зүйг баримт бичиг, зөвлөмжид тусган ажилладаг байхад анхаарах

2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Commented [U6]: Энэ нь яагаад онцлог зүйл туршлага болно гэж үзсэн бэ?

Commented [U7]: Найруулгыг засах, бичгийн найруулгаар бичих

Commented [U8]: Найруулгыг засах

Commented [U9]: Найруулгыг засах

Commented [U10]: Үзэж танилцсан баримт нотолгоогоо оруулах

Commented [U11]: Энд бичсэн зүйлс анхаарах асуудал үү? зөвлөмж үү?

Илрэл нотолгоо:

- ✓ Хөтөлбөрийн явцад оюутны мэдлэг, ур чадвар, хандлагын түвшинг Блумийн таксономор, үр дүнгийн гүйцэтгэлийг үнэлэх шалгуур боловсруулан үнэлгээний аргуудыг хослуулан хэрэглэдэг
- ✓ Хичээл нэг бүрийн үнэлгээнд үнэлгээний асуулт даалгавар, сорилын сан, кейс анализ хэлбэрүүдийг ашигладаг
- ✓ Явцын болон төгсөлтийн шалгалтын журам, бусад заавар дүрмийг ОЮУТНЫ ГАРЫН АВЛАГА -д тусган суралцагчийн үнэлгээ нь ил тод, найдвартай, шударга, ижил тэгш зарчмыг ханган ажилладаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрөөр олж авсан мэдлэг чадвар нь төгсөгчдийн ажлын байранд тавигдах шаардлагыг бүрэн хангаж байгаа гэсэн төгсөгчдийн үнэлгээ, сэтгэл ханамж сайн.

Анхаарах асуудал:

- Суралцагчийн сурлагын амжилт, ахицын талаарх статистик мэдээлэл, боловсруулалт, дүгнэлт, голч дүн, хичээлд хангалтгүй үнэлгээ авсан оюутны тоо, амжилт чанар, сурлагын ахицын талаарх статистик мэдээллийг тэнхимийн нийт оюутны тоогоор улирал бүр гаргадаг байх
- Чадамжид суурилсан, оюутны оролцоо төвтэй хөтөлбөр хэрэгжүүлж байгаатай уялдуулан чадварыг хэмжээсжүүлэх үнэлгээний хэлбэрүүдийг түлхүү ашиглах
- Сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээл нэг бүрийн үнэлгээний арга, хэлбэр нь суралцагчдыг тасралтгүй хөгжихөд хөтлөх боломжийг бүрдүүлэх, хичээл бүрээр явцын болон улирлын үнэлгээний ахиц дэвшлийн анализ хийдэг байх

Зөвлөмж:

- Тухайн хичээлийн агуулгад суурилсан оюутны бие даасан ажлын үнэлгээний рубрик боловсруулан үнэлгээнд ашигладаг байх
- Үнэлгээний шалгуурт оюутны бүтээлч үйл ажиллагаа, суралцах сэдэл, хандлагад чиглэсэн үйл ажиллагааг үнэлэх хэмжүүрээр хэмжихийг чухалчлах

2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, нөөц

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Илрэл нотолгоо:

- ✓ СУИС-ийг 2018-2024 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө: Их сургуулийн сургалт, эрдэм шинжилгээ, уран бүтээлийн таатай орчинг бүрдүүлж хөгжүүлэх стратеги
- ✓ Хичээлийн 3-р байр нь 1956 онд баригдсан, мэргэжлийн хяналтын байгууллагын актаар нурах аюултай гэж дүгнэгдсэн байна.
- ✓ Сургалтын болон захиргаа аж ахуйн хэрэглээнд шаардлагатай хөрөнгө худалдан авах, тохижилтын зардлыг жилийн батлагдсан төсвийн хүрээнд төлөвлөдөг.
- ✓ Соёлын сургуулийн 3-р хичээлийн байрны номын санг засварлаж тохижуулан эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагад нийцүүлэн хийсэн байна. Сургууль дээр

Commented [U12]: Зөвлөмжид бичсэн зүйл анхаарах асуудалтайгаа холбоотой байх хэрэгтэй

ажиллаж өөрийн үнэлгээний тайланд тусгасан мэдээллүүдийг баталгаажуулсан тэмдэглэл.

- ✓ 2018 онд зайн сургалтын лаборатори байгуулсан \104 тоот өрөө\
- ✓ Сургуулийн орчин болон бүх анги танхимд хяналтын камер болон галын аюулгүй ажиллагааны шаардлага хангасан дохиолол, гарцын схем, галын хэрэгслээр хангагдсан.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Өөрийн сургуулийн нөөцөд тулгуурлан анги танхим болон бусад лабораторийг дээд боловсролын сургалтын байгууллагын шаардлагад нийцүүлэн засварлаж тохижуулсан.
- Жил болгон урсгал засвар тогтмол хийдэг.
- Цахим орчин бие даан болон багаар ажиллах орчны хангалтыг динамик платформд хийдэг.
- 2018 оноос сургалт, судалгаа явуулах өөрийн анги танхимтай болсон.
- Хичээлийн 2-р байрны компьютерын лабораторийг 1,2-р курс, 3-р байрны компьютерын лабораторийг 3,4-р курсүүд бүрэн ашигладаг нь шаардлагад нийцэж байна. \Компьютерын үзүүлэлт нь I5\

Анхаарах асуудал:

- Хичээлийн 3-р байрны насжилт өндөр 1956 онд баригдсан, мэргэжлийн хяналтын байгууллагын актаар нурах аюултай гэж дүгнэгдсэн.
- Хөгжлийн онцлогтой оюутанд зориулсан 3-р байрны хаалганы босгонд пандус, бусад шаардлагатай зүйлсийг хийх шаардлагатай.
- Суралцагчдын биеийн тамирын хичээлд зориулсан заал, дасгалын өрөө байхгүй.
- Сургуулийн байрны чанар, өнгө үзэмж муу.

Зөвлөмж:

- Суралцагчдын эрүүл мэнд, бие бялдрыг хөгжүүлэх биеийн тамирын заал, дасгалын өрөөтэй болох, эсвэл түрээсийн гэрээ байгуулах.
- Шинэ барилга байгууламжтай болтол одоогийн ашиглаж байгаа хичээлийн 3-р байрны хаалганы босгонд хөгжлийн онцлогтой оюутанд зориулсан пандус хийлгэх
- Барилгад хүчитгэл хийж угсрах, урсгал засварыг чанартай сайн хийж гүйцэтгүүлэх.

3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- ✓ Цар тахлын үед СУИС-аас Соёлын сургуульд зайн сургалтын тоног төхөөрөмжийн худалдан авалт хийж хичээл сургалтыг цахим хэлбэрт шилжиж ажилласан.
- ✓ 2020-2021 онд 26 төрлийн 120 ширхэг сургалтын тоног төхөөрөмжийг шинээр авч анги танхим, лабораториудад тохижуулан тоногдосон.
- ✓ Сургуулийн орчинд өндөр хурдны интенэт орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн.
- ✓ Багш нарт зөөврийн болон суурин компьютеруудыг тус бүрд нь хангасан.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сургалтын хэрэглэгдэхүүн, нөөцийн жагсаалт, хүртээмж, ашиглалтын талаар сэтгэл ханамжийн судалгаа жил бүр хэвлэмэл болон цахимаар аван сургуулийн үзүүлэлт дунджаас дээгүүр гарч байна. 5 оноо авахаас 3.5 байна.
- Сургалт явуулахад шаардлагатай хичээл практикийн материаллаг баазтай.
- Ж.Цэзэн, Т.Хайдав, А.Алтанчимэг, Д.Энхтунгалаг гэсэн зохиогч нарын мэргэжлийн хичээлийн 24 сурах бичигтэй.
- Хэвлэмэл үзүүлэн, тараах материал цахим эх үүсвэр, боловсруулан ашигладаг. E-контент түвшинд боловсруулсан сургалтын материалыг Т.Хайдав багш боловсруулан хэрэглээнд нэвтрүүлсэн.
- Сургуулийн нярав, нягтлан сургалтын хэрэглэгдэхүүн, нөөцийн жагсаалт хөтөлдөг.

Анхаарах асуудал:

- Цахим тоног төхөөрөмж, лабораторийн шинэчлэл жил бүр тодорхой хэмжээнд хийгддэг боловч орчин үеийн сургалтын цахим хэрэглүүр, программ хангамжийг нэвтрүүлэх, техник тоноглол шаардагдаж байна.
- Сургалтад хэрэглэгддэг техник тоног төхөөрөмж технологийн хоцрогдолтой байна.

Зөвлөмж:

- Сургалтад ашиглаж байгаа тоног төхөөрөмжүүдийг бие даалтын үед оюутнуудад тогтмол ашиглах боломжийг бий болгох.
- Орчин үеийн шаардлагад нийцсэн сургалтын цахим хэрэглүүр, программ хангамжийг нэвтрүүлэн ашиглах.

3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- ✓ Мэргэжлийн ном, сурах бичгийн баяжилт, шинэчлэлтийн судалгаа жил бүр хийгддэг.
- ✓ Судалгааны ажилд дэмжлэг үзүүлэх зорилгоор EBSCO мэдээллийн санг 2017 оноос түрээслэн ашиглаж байна.
- ✓ Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.
- ✓ Сургууль тэнхимээс хөтөлбөр дагасан сурах бичиг гарын авлага шинээр боловсруулах, хэрэгцээ хангамжийг нэмэгдүүлэхэд анхааран ажилладаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Соёлын сургууль нь доктор профессор багш Ж. Цээнгийн удирдлагаар Монголын их дээд сургуулиудын 20,000 орчим сургалтын хэрэглэгдэхүүнийг цахимжуулж, Монголын Улсын Үндэсний номын санд “ЭСТ” мэдээллийн бий болгон тусгай эрхээр ашигладаг болсон
- 2019 оноос eBook Academic subscription collection багцыг түрээслэн ашиглаж байна. Тус сангаас нийт 534 материалын мэдээллийн сантай болсон.
- Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.
- 2021 онд EBSCO мэдээллийн сангаас 210,000 орчим номтой eBook Academic Collection Trial багцтай болсон.

Анхаарах асуудал:

- Номын сангийн цахим сан хөмрөгийн баяжилт E-сэтгүүл, E-диссертац бичвэрийн фонд бүрдүүлэлт бага байна.
- Санхүүгийн боломж бололцооны улмаас ном, сурах бичгийн фондыг шинэчлэх, нэмэгдүүлэх боломж муу байна гэсэн. \Багш нарын уулзалтын тэмдэглэлээс\

Зөвлөмж:

- Санхүүгийн боломж бололцооны улмаас ном, сурах бичгийн фондыг шинэчлэх, нэмэгдүүлэх боломж муу ч гэсэн энэ тал дээр анхаарал хандуулж боловсролын байгууллагуудад зориулагдсан олон улсын төсөл хөтөлбөрт хандаж санхүүжилт босгох боломжийг судлах.
- Багш нар өөрсдөө бас олон улсын түвшний мэдээлэл дээр тулгуурлан хичээл сургалтаа зохион байгуулах, сурагчдаа дэмжиж туслах, бие даасан судалгааны ажлуудыг илүү хийлгэхийг зөвлөж байна.
- Номын сангийн цахим сан хөмрөгийн баяжилт E-сэтгүүл, E-диссертац бичвэрийн фонд бүрдүүлэлтийг нэмэгдүүлэх.

3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- ✓ Хөтөлбөрийн дэд хороог СУИС-ийн захирлын 2014 оны 115 дугаар тушаалаар байгуулсан ба мөн 2019 оны А/203 тоот тушаалаар бүрэлдэхүүнийг шинэчлэн ажиллаж байна. Хөтөлбөрийн хороогоор хэлэлцсэн асуудлыг СУИС-ийн эрдмийн зөвлөлөөр хэлэлцэж эцэслэн баталдаг байна.
- ✓ Суралцагчдаас ирсэн санал гомдлыг тухай бүрд нь аль болох хэрэглэгч-оюутан суралцагчдад ээлтэй байдлаар шийдвэрлэдэг бөгөөд нийтлэг асуудлууд нь суралцах хэлбэрээ өөрчлөх, хичээл дүйцүүлэх, чөлөө хүсэх, үргэлжлүүлэн суралцах, дадлага хийх газраа өөрөө сонгох зэрэг байдаг байна.

- ✓ Оюутны дадлагыг хамтын ажиллагааны гэрээний дагуу Үндэсний номын сан, Хүүхдийн төв номын сан, УБ хотын нийтийн төв, аймгийн төв номын сан болон их дээд сургуулийн номын санд хийлгэдэг ба ингэхдээ зөвхөн хичээлийн хөтөлбөрийн хүрээгээр хязгаарлалгүйгээр хэрэглэгчдэд үйлчилгээ үзүүлэх талбарт ч мөн дадлагдаж буй нь ажлын байрны бодит байдалтай танил болох, төгсөөд шууд ажиллах ур чадвар эзэмших, байгууллагын орчинд дасан зохицох сэтгэл зүйн бэлтгэлтэй болгодог олон талын ач холбогдолтой нь байдаг байна.
- ✓ СУИС-ийн захирлын нэрэмжит тэтгэлэг жил бүр 1-2 оюутан авдаг. Тухайлбал сүүлийн 5 жилд нийт 8 оюутан тэтгэлэгт хамрагджээ.
- ✓ Ажил олгогчид тэр дундаа зорилтот ажил олгогч номын сан (Үндэсний номын сан, Хүүхдийн төв номын сан, УБ хотын нийтийн төв ном)-уудтай хамтын ажиллагааны гэрээ байгуулж хамтран ажиллаж байна. Гэрээг 2021, 2022 онд шинэчилжээ.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийг шинэчлэх, сайжруулахдаа оролцогч талуудын санал, хүсэлт, хэрэгцээ шаардлагыг тусгадаг. Оролцогч талуудад оюутан суралцагчид, төгсөгчид, ажил олгогчид, номын санч мэдээллийн ажилтнууд, мөн мэргэжлийн холбоодууд багтдаг байна.
- Хөтөлбөр нь төгсөгчтэйгөө олон нийтийн сүлжээний хаалтай группийн сувгаар байнгын холбоотой ажиллаж, тэдний хөгжүүлэх хөтөлбөрийн хэрэгцээ шаардлага болон ажил эрхлэлтийн судалгааг тогтмол хийдэг байна.
- Хөтөлбөр нь ажил олгогч байгууллагуудын зэрэгцээ хөтөлбөрийг сайжруулах чиглэлээр ТББ-уудтай ч мөн хамтран ажилладаг. Тухайлбал: Монголын номын сангуудын консорциумоос зохион байгуулдаг "Mongolian library update" номын санч-мэдээллийн ажилтнуудын улсын зөвлөгөөнийг 2017, 2019 онуудад хамтран зохион байгуулж, сургалтын хөтөлбөрийн шинэчлэл, номын санчдын сургалтын хэрэгцээ сэдэвт хэлэлцүүлэгүүдийг зохион байгуулсан байна.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжийн урт, дунд, богино хугацааны тайлан, төлөвлөгөөг тогтмолжуулах, хэрэгжилтэд анхаарах
- Тайлан төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээг баримтжуулах, баталгаажуулах.
- Хөтөлбөрийн хороо, тэнхимийн хурлын шийдвэр, тэмдэглэлийг баримтжуулах, тогтмолжуулах

Зөвлөмж:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжийн урт, дунд, богино хугацааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх, хөтөлбөрийн элсэгч, суралцагчийн хувийг нэмэгдүүлэхэд сургуулийн болон төрийн бодлогоор дэмжихэд анхаарал хандуулах
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгчийн эрх мэдлийг нэмэгдүүлэх, менежментийг нь сайжруулах

4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- ✓ Монголын номын сангуудын консорциум, Монголын номын санчдын “Таван ухаан” холбоо, ЕБС-ийн номын санчдын холбоо зэрэг байгууллагуудтай хамтран ажилладаг.
- ✓ 2017, 2019 онд Монголын номын санч-мэдээллийн ажилтнуудын Улсын зөвлөгөөнийг хамтран зохион байгуулж, Номын сан судлал хөтөлбөрийн шинэчлэлийн асуудлаар салбар хуралдаан удирдаж, түүний үр дүнд 3 хичээлийн хөтөлбөрийг шинээр боловсруулсан. Мөн зарим хичээлийн хөтөлбөрийн агуулгад өөрчлөлт хийгдсэн.
- ✓ ОХУ-ын Улаан-Удэ хотын Дорнод Сибирийн Соёлын сургуультай эрдэм шинжилгээний хурлыг жил бүр ээлжлэн зохион байгуулж, багшийн хөгжлийн чиглэлээр хамтран ажилладаг.
- ✓ Сүүлийн 5 жилд Т.Хайдав (АНУ, ОХУ), А.Алтанчимэг (Филиппин), Б.Амарзаяа (ОХУ) нар мэргэжил дээшлүүлэх тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдсан байна.
- ✓ АНУ-ын Конгрессын номын сангийн номын санч М.Саруул-Эрдэнэтэй Зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулж ажиллаж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Ажил олгогч байгууллагууд болон мэргэжлийн холбоод, Төрийн бус байгууллагуудтай хамтран ажилладаг байна.
- ИФЛА (Номын сангийн олон улсын холбоо) Үндэсний номын сантай хамтран “Номын сангийн-Алсын хараа” зөвлөгөөнийг зохион байгуулжээ.
- Номын сан судлалын тэнхимийн эрхлэгч Т.Хайдав нь ОХУ-ын Дорнод Сибирийн Соёлын дээд сургуулийн Декан Е.А. Кучмуруковатай хамтран Соёлын сургуулийн “Номын сан судлал” хөтөлбөрийг зарим улс (Тайван, Кени, ОХУ)-ын хөтөлбөртэй харьцуулан судалж хөтөлбөрт шаардлагатай шинэчлэлтийг хийсэн байна.
- Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Соёлын орон зай” эрдэм шинжилгээний хурлыг тогтмол зохион байгуулж, хурлын материалыг эмтхэтгэн хэвлүүлсэн байна.

Зөвлөмж:

- Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар багш нарыг хөгжүүлэх, чадавхжуулах
- Оюутны солилцоо, тэтгэлэгт хөтөлбөрүүдийг нэмэгдүүлэх
- Төгсөгчдийн холбооны үйл ажиллагааг идэвхжүүлэх

4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Илрэл нотолгоо:

- ✓ Хөтөлбөрийн нийт санхүүжилтийн 90 гаруй хувийг сургалтын үндсэн үйл ажиллагаанд зарцуулдаг байна. Үндсэн орлого нь оюутны сургалтын төлбөр бөгөөд нэг кредитийн төлбөр 64,200 төгрөг байна.
- ✓ СУИС-ийн дэргэд Соёлын ажилтны мэргэжил дээшлүүлэх институтийг байгуулсан бөгөөд салбарын ажилтнуудад богино хугацааны сургалт зохион байгуулдаг. Уг богино хугацааны сургалтын төлбөрийн тодорхой хэсэг нь багш нарын орлогын нэг эх үүсвэр болдог.
- ✓ Номын сангийн салбарт ажиллаж байгаа ажилтнуудын 50 гаруй хувь нь мэргэжлийн бус байдаг тул хөтөлбөрийн эчнээ сургалтын эрэлт хэрэгцээ их байдаг байна.

- ✓ Оюутны хөгжлийг дэмжих үүднээс бүтээлч оюутан төслүүдийг жил бүр хэрэгжүүлдэг. Мөн СУИС-ийн захирлын нэрэмжит оюутны тэтгэлэг нь 500,000 төгрөг бөгөөд Номын сан судлал хөтөлбөрөөс жилд тогтмол 1-2 оюутан хамрагддаг байна

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрт элсэгчдийн тоог нэмэгдүүлэх, өрсөлдөх чадварыг сайжруулах
- Номын сан судлал хөтөлбөрөөр суралцагчдад төрийн бодлогоор сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлэх, тэтгэлэг олгох талаар анхаарч ажиллах

Анхаарах асуудал:

- Өдрийн болон эчнээ хөтөлбөрийн хичээлийн агуулга адил боловч үнэлгээ өөр байна.
- Өдрийн болон эчнээ ангид хичээл заасан багшийн цагийн үнэлгээг ижил болгох
- Эчнээ ангийн орлого багшийн орлогын эх үүсвэрт дэмжлэг болж буй хэдий ч ачаалал ихтэйг анхаарах

Зөвлөмж:

- Багшийн хөгжлийг дэмжих, мэргэжлийн багшийн залгамж, хүний нөөцийг бэлтгэхэд холбогдох санхүүжилтийг төлөвлөх, зарцуулах

4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- ✓ Номын сан судлал хөтөлбөрийг сурталчлах, олон нийтэд таниулах зорилгоор үзэсгэлэн, видео шторк, мэргэжил сурталчлах өдөрлөг зэргийг зохион байгуулдаг байна.
- ✓ СУИС-ийн хүрээнд маркетинг хариуцсан ажилтантай, орон нутгаас оюутан элсүүлэх ажилд багш нарыг томилон ажиллуулдаг байна.
- ✓ Орон нутагт тусгайлан номын сан судлал мэргэжлийг сурталчлах өдөрлөг зохион байгуулж, үүний үр дүнд 45 оюутан элсүүлсэн туршлага байна.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн сурталчилгаа идэвхжүүлэлтийг Соёлын сургууль нь олон нийтэд нээлттэй таниулах, сурталчлах, сүүлийн жилүүдэд мэдээллийн бүх төрлийн хэрэгслийг ашиглаж, хэрэгжүүлдэг. Үүнд хамтарч ажилладаг телевиз, радио, сонин, сайтуудаар сурталчилдаг.
- СУИС-ийн үндсэн вэб сайт www.mnuac.edu.mn болон олон нийтийн түгээмэл хэрэгсэл болох фэйсбүүкийг өргөн ашиглаж байна.
- Жил болгон Соёлын сургууль нь аймаг орон нутгийн Соёл урлагийн газартай хамтран зохион байгуулдаг

Анхаарах асуудал:

- Номын сан судлал хөтөлбөрийн талаар маркетингийн тусгай төсөл боловсруулж, хэрэгжүүлэх
- Тус сургууль нь соёл, урлагийн менежмент, маркетингийн хөтөлбөрөөр мэргэжилтэн бэлтгэдэг бөгөөд НСС хөтөлбөрийн маркетингийг сайжруулах, идэвхжүүлэхэд дотоод нөөц боломжийг ашиглах талаар анхаарах

- Маркетингийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, маркетингийн үр дүн, үр нөлөөг тооцож байгаа байдалд анхаарах

Зөвлөмж:

- Багшлах бүрэлдэхүүн, төгсөгчид, ажил олгогчдын нөөцийг ашиглан номын сангийн салбар болон, номын санчдын мэргэжлийн үнэлэмж, нэр хүндийг өсгөх, олон нийтэд хандсан контентыг бүтээх замаар элсэгчдийн тоог нэмэгдүүлэх
- Номын санд ажиллаж байгаа мэргэжлийн бус хүмүүс эчнээгээр суралцах сонирхол их байгаа нь хөтөлбөрийн эрэлт хэрэгцээтэйг харуулж байна. Энэ эрэлт хэрэгцээг зөв мэдэрч ашиглах

4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Илрэл нотолгоо:

- ✓ СУИС-ийн үндсэн вэб сайт www.mnuac.edu.mn болон олон нийтийн түгээмэл хэрэгсэл болох фэйсбүүкийг өргөн ашиглаж байна.
- ✓ Монгол Улсын Засгийн газрын 2002 оны 1-р сарын 25-ны өдрийн “Зайн сургалтын үндэсний хөтөлбөр батлах тухай” тогтоол, СУИС-ийн мастер төлөвлөгөө, 2016 оны СУИС-ийн “Зайн сургалтын журам”, СУИС-ийн “Вэб сайтын үйл ажиллагааг зохицуулах”, “Вэбсайтын онлайн бүртгэл үйлчилгээний түр журам” зэрэг эрх зүйн баримт бичигт үндэслэн сургуулийн орчинд цахим эх сурвалжийг ашигладаг байна.
- ✓ Хөтөлбөрийн талаар багш нар, төгссөн оюутнууд, одоо сурч байгаа оюутнууд нь олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сургуулийн цахим хуудас (<https://scc.mnuac.edu.mn>)-аар дамжуулан тэнхим, хөтөлбөрийн бүтэц, багшлах бүрэлдэхүүн, үйл ажиллагааны талаар мэдээлэл түгээдэг.
- MNS 5323-130:2013 “Номын сан судлал-мэдээлэл” D320400 мэргэжлийн стандарт боловсруулж Стандарт, хэмжил зүйн газраар батлуулсан.
- Элсэлт төгсөлтийн мэдээллийг (<https://scc.mnuac.edu.mn>) цахим хуудсаар нээлттэй мэдээлдэг.

Анхаарах асуудал:

- Номын сан болон номын санч-төгсөгчид, бусад оролцогч талтай хамтран мэргэжлийг сурталчлах, олон нийтэд дэлгэрэнгүй мэдээлэл хүргэх
- Мэдээлэл технологи, олон нийтийн сүлжээний өргөн боломжийг ашиглан, дотоод нөөц боломжийг дайчлан, зөвхөн мэргэжил сонголтын чиглэлээр бус номын сантай холбоотой тусгай контентуудыг бүтээх, түгээх

Зөвлөмж:

- Төрийн анхаарлыг татах, тодорхой төсөл, хөтөлбөр бодлого санаачилж дэвшүүлэх, дэмжлэг авах

4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- ✓ Суралцагч сонгон элсүүлэх журмыг СУИС-ийн захирлын 2020.04.21-ний А\90 дүгээр тушаалаар шинэчилсэн. Тухайн жилүүдэд гарсан нэмэлт өөрчлөлтүүдийг үндэслэн элсэлтийн ажлыг зохион байгуулдаг. Номын сан судлал хөтөлбөрөөр элсэгчид ерөнхий шалгалтын босго оноо 480.
- ✓ Элсэн орогчдын тоо жил бүр харилцан адилгүй бөгөөд сүүлийн жилд ЕБС-ийн төгсөгчид өдрийн ангид элсэх нь багассан байна.
- ✓ Номын сан судлал хөтөлбөрийг дэмжих төрийн бодлого, нэр хүндийг өсгөх шаардлагатай байгаа нь энэ хөтөлбөрт сурах хүсэлтэй оюутны тоонд эергээр нөлөөлж байгаа гэж багш нар ярьж байна.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Зорилтот мэргэжлийн бүлэгт хамруулах зорилгоор сургуулийн удирдлагын зүгээс дээд шатны холбогдох байгууллагуудад удаа дараа хүсэлт, албан тоот явуулж байсан.
- Элсэн суралцагчдыг угтах үйлчилгээ олон талаар тогтмолжсон- \зөвлөх багш, сургалтын алба, оюутны холбоо, эмч, дотуур байр, номын сан гэх мэт.\
- Ажлын байрны эрэлт хэрэгцээ өндөр байна.

Анхаарах асуудал:

- Шинээр элсэх хүсэлтэй оюутнуудад зориулсан сургалтын төлбөрийн хөнгөлөлт, дэмжлэг, тэтгэлэгт хамрагдах мэдээлэл маш бага байна.
- Оюутан суралцагдахад хичээл болон багшаа сонгох боломж өгөх
- “Номын сан судлал” мэргэжлийн тухай нийгэмд түгээн дэлгэрүүлэх, олон нийтэд мэдээлэл хүргэх, сургалтын хөтөлбөрийн онцлог, ЕБС-ийн төгсөх ангийн сурагчдад “Номын сан судлал” мэргэжлийн талаар мэргэжлийн баримжаалал олгох үе шаттай үйл ажиллагаа байхгүй

Зөвлөмж:

- Сүүлийн үед мэргэжлээ сурталчлах шинэ арга болгож, багш нараараа мэргэжил болон хичээлийнх нь талаар видео танилцуулга хийлгэх
- Шинээр элсэх хүсэлтэй оюутнуудад зориулсан дэмжлэг тэтгэлэгт хамрагдах талаар менежмент хийн хүссэн мэдээллээ авах боломжийг олгох.
- Олон нийтийн сүлжээгээр “Номын сан судлал” хөтөлбөрийн талаар болон энэ мэргэжлийн ач холбогдлын талаар илүү сурталчлах.
- Төгсөгчдийн 90 гаруй хувь нь ажлын байраар хангагддаг, мөн энэ мэргэжил нь хөдөлмөрийн зах зээл дээр эрэлт ихтэй мэргэжил гэдэг давуу талаа сурталчилгаандаа оруулах.
- “Номын сан судлал” мэргэжлийн тухай нийгэмд түгээн дэлгэрүүлэх, олон нийтэд мэдээлэл хүргэх, сургалтын хөтөлбөрийн онцлог, ЕБС-ийн төгсөх ангийн сурагчдад “Номын сан судлал” мэргэжлийн талаар мэргэжлийн баримжаа олгох үе шаттай үйл ажиллагааг өөрийн сургуулийн төгсөгчид болон мэргэжлийн байгууллагуудтай хамтран

зохион байгуулж, ажиллах, сургалтын хөтөлбөрийг зах зээлийн эрэлтэд тулгуурлан, хэрэгцээний судалгаанд үндэслэн тасралтгүй хөгжүүлдэг цикл үүсгэх

5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- ✓ Шинээр элссэн оюутнуудын зөвлөх багштай.
- ✓ СУИС-ийн хэмжээнд 2018 оны 4-р сарын 24-ний А\146-р тоот тушаалын хавсралтаар батлагдсан СУИС-ийн оюутны зөвлөх багш ажиллуулах журам"-ыг сургалтын үйл ажиллагаанд мөрдөж ажилладаг.
- ✓ Зөвлөх багш шинэ оюутнуудад зөвлөгөө өгөх, сурч боловсрох үйл ажиллагаанд нь дэмжих, туслах, оюутныг хөгжүүлэх судалгааны ажлын чадвар дадал олгох, оюутны ажил эрхлэлт, төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн ажил үйлчилгээ хийх, оюутны төлөвшил, ёс зүйн харилцааг дээшлүүлэхэд чиглэсэн ажлуудыг зохион байгуулдаг байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- СУИС-ийн Оюутны зөвлөл нь тасралтгүй үйл ажиллагаагаа явуулж байгаа нь оюутнуудын нийгмийн идэвх оролцоог хангах боломж бүрдүүлдэг.
- 2016 оноос хойш суралцагчдын сэтгэл ханамжийн судалгааг уламжлал болгон явуулж үр дүнд нь тулгуурлан үйл ажиллагаагаа сайжруулж байгаа нь сайшаалтай. Зөвлөх багш ажиллуулдаг нь сайн туршлага гэж үзэж байна.
- Шинэ орчинд орж ирж байгаа оюутнуудад сургууль болон суралцах үйл явцад хурдан дасан зохицоход нь маш их давуу тал үүсгэж байгаа гэж үзэж байна.
- Оюутнуудаас авсан сэтгэл ханамжийн судалгаанд зөвлөх багшийн талаарх оюутнуудын үнэлгээ өндөр байсан нь үүнийг нотолж байна.

Анхаарах асуудал:

- Суралцагчдад зөвлөн туслах багш нар үндсэн орон тооны багш байх ёстой.

Зөвлөмж:

- Оюутнуудад зөвлөн туслах багш нар үндсэн орон тооны багш бий болгох. \Ангийн багш гэсэн үг\
- Багш, оюутнууддаа өөрийгөө үнэлэх, чадвараа нээж олоход нь туслах

5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшуулал

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- ✓ "Суралцагчдын идэвх оролцоо, нийгэмд чиглэсэн ажлыг үнэлэх түр журам"-ыг СУИС-ийн захирлын 2020.06.11-ний А\134 дүгээр тушаалаар батлан оюутны хөгжлийг дэмжих үйл ажиллагаа, идэвх санаачилгыг өрнүүлэх зорилгоор суралцагчдад олгох тодорхойлолт, түүнд цаг тооцох харилцааг зохицуулдаг байна.
- ✓ Сургуулийн зүгээс гаргасан урамшуулалт тэтгэлгийг 5 оюутан 2018-2020 авсан байна.
- ✓ Оюутны хөгжлийн зээл болон тэтгэлэгт 4 оюутан 2018-2020,

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- СУИС-ийн “Суралцагчдын идэвх оролцоо, нийгэмд чиглэсэн ажлыг үнэлэх түр журам”-ыг баримталдаг
- Суралцагчдын сурах идэвхийг өрнүүлэх, санаа санаачилгыг дэмжих, хөнгөлөлт урамшуулал, тэтгэлэгт хамруулах тогтолцоо бүрдсэн.
- Оюутнууд нийгэмд хэрэгтэй зүйлд цаг, сэтгэл гаргахад нь сургууль, багш нарын зүгээс дэмжиж ажилладаг.
- Оюутнууд нь “Бүтээлч оюутан” төсөлд амжилттай оролцсоноор янз бүрийн нийгмийн тустай ажилд идэвхтэй хамрагдан төслийн санхүүжилт, тоо хэмжээ нэмэгдсэн. \Жилийн дундаж 34,2%-аар нэмэгдсэн\

Анхаарах асуудал:

- Номын сангийн салбар болон, номын санчдын мэргэжлийн үнэлэмж, нэр хүндийг өсгөх, олон нийтэд хандсан контент байхгүй байна.

Зөвлөмж:

- Оюутнуудын суралцах идэвх, бүтээлч санаачилгыг өрнүүлэх тал дээр оюутны өөрийн удирдлагын байгууллагыг тогтмол ажиллуулдаг албадуудтай болох.
- Сурлагын амжилтаар тэргүүлэгч оюутнуудыг бусад оюутны дунд алдаршуулан, урамшуулах шинэ аргуудыг олох шаардлагатай байна.

5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Илрэл нотолгоо:

- ✓ Судалгаагаар 2018 онд 2-р курсийн 1 оюутан шилжсэн мэдээтэй.
- ✓ СУИС-ийн сургалтын үйл ажиллагаанд холбогдох журмын 5.3 дугаар зүйл “Оюутны шилжилт, хөдөлгөөнийг зохицуулах журам”-ыг мөрдлөг болгон ажилладаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**Онцлог зүйл/Туршлага:**

- Оюутан суралцаж байх хугацаандаа 3 удаа жилийн чөлөө авах эрхтэй байдаг. Өргөдлийн шалтгаанаас хамаарч өөр өөр байдаг.
- Оюутан ар гэрийн байдал, эрүүл мэндийн шалтгаан, сургалтын төлбөрийн боломжгүй зэргээс гол төлөв шалтгаалан чөлөө авдаг юм байна.
- Нэг оюутны сургалтын үргэлжлэх хугацаа уян хатан байдаг.
- СУИС-ийн сургалтын үйл ажиллагаанд холбогдох журмын 5.3 дугаар зүйл “Оюутны шилжилт, хөдөлгөөнийг зохицуулах журам”-ыг мөрдлөг болгон ажилладаг.

Зөвлөмж:

- Оюутны шилжих хөдөлгөөнийг өөрийн сайн дурын үндсэн дээр явуулдаг бөгөөд асуудлын гол шалтгааныг тодруулах, шийдвэрээ зөв гаргахад нь туслах зөвлөл байгуулах

5.5. Төгсөлтийн баримт бичиг

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

Илрэл нотолгоо:

- ✓ СУИС-ийн захирлын 2015 оны 6-р сарын 5-ны өдрийн А\149 дүгээр
- ✓ Шалгалтаар болон дипломын ажил хийсэн оюутны тоо мэдээлэл гаргаж, харьцуулсан судалгаанд 196 төгсөгч хамрагдсан. 141 төгсөгч шалгалтаар, 55 дипломын төсөл хийсэн.
- ✓ 2020 оноос шалгалтаар төгсгөхөө больсон.
- ✓ Энэ хөтөлбөрт суралцаж төгссөн хэд хэдэн төгсөгч мэргэжлээрээ гадаадад суралцаж төгссөн. Төгсөгчидтэй уулзсан цахим уулзалтаар

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Төгсөлтийн баримт бичгийг олгох дүрэм журмын дагуу 126 кредитээс багагүй багц цагийн хичээл, 2,0-оос дээш голч дүнтэй оюутанд бакалаврын диплом олгодог.
- “СУИС-ийн бакалаврын сургалтын журам”-ыг баримтлан журамд заасан шалгуурыг хангасан оюутнуудыг төгсөлтийн ажил, төслийн ажлыг бичдэг.
- Төгсөгчидтэй уулзсан уулзалтаас харахад төгсөлтийн баримт бичиг болон түүний олголтын талаар хүндрэл гардаггүй тухай дурдаж байсан. Төгсөгчид төгсөөд ажлын байранд хангалттай сайн хамрагдаж чаддаг.
- Төгсөлтийн ажил хамгаалсан оюутнуудад төгсөлтийн комиссын гишүүдийн гарын үсгээр баталгаажсан шийдвэрт үндэслэн СУИС-ийн захирлын тушаалаар төгсөлтийн баримт бичиг олгогддог.
- Оюутны хөдөлмөр эрхлэлттэй холбоотой бичиг, баримт, тайлангууд гаргадаг.

Анхаарах асуудал:

- Төгсөгчдийн холбоо байхгүй байна.

Зөвлөмж:

- Төгсөгчдийн холбоо байгуулж, үйл ажиллагааг идэвхжүүлэх
- Төгсөгчдийн тоо мэдээлэл нарийвчлан гаргаж, эргэх холбоо үүсгэн идэвхжих
- Үйлдвэрлэлийн дадлагыг оюутны ажиллах сонирхолтой байгууллагад хийлгэн төгсөлтийн ажлын сэдвийг сонгуулах нь үр дүнтэй

5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 6. Багшлах бүрэлдэхүүн

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Илрэл нотолгоо:

- ✓ СУИС-ийн захирлын 2015 оны 6-р сарын 5-ны өдрийн А\147, мөн 2018 оны 6-р сарын 25-ны өдрийн А\230 тоот тушаалын 2-р хавсралт СУИС-ийн тэнхимд тавигдах шаардлага, профессор багш ажиллуулах журмын 6-р зүйлийн А, Б 2020 онд шинэчлэн найруулсан дүрэм журмуудыг үйлт ажиллагаандаа мөрдлөг болгодог.
- ✓ Багшийн нөөцийн төлөвлөлт, сонгон шалгаруулалтыг СУИС-ийн захирлын 2022.01.03-ны Б\01 тушаалаар шинэчлэн баталснаар үндсэн орон тоонд 2 багш, гэрээтээр 2 багш ажиллуулж байна.

- ✓ 2016-2020 оны хооронд Номын сан судлалын тэнхимийн багш нарт 9.348.2 төгрөгийн урамшуулал олгосон.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- СУИС нь урамшууллын нэгдсэн системтэй
- Багшийн нөөцийн төлөвлөлт, сонгон шалгаруулалтыг СУИС-ийн захирлын шийдвэр, тушаалаар жил болгон гаргадаг.
- Багш нарт олгосон урамшууллын судалгаа хүснэгтээр гаргасан. 2018 оноос хойш өнөөдрийг хүртэл холбогдох байгууллагуудад тодорхойлолт хүсэлтүүд жил бүр өгдөг.

Анхаарах асуудал:

- Тэнхимийн багш нарын судалгааны ажлын чиглэл тодорхой болгон, нөөц хүчин чадал бага байна.
- Хөтөлбөрийн багш нар нь нэг хичээлийн жилд 4-5 төрлийн хичээл заадаг нь цагийн ачаалал өндөр байна.
- Номын сан судлал хөтөлбөрт докторын зэрэгтэй 1, магистрын 3 багш байгаа нь хангалтгүй байна.
- “Номын сан судлал мэдээлэл” мэргэжилтний стандартад заасан мэргэжлийн тодорхойлолт, төгсөгчдийн мэргэжлийн бэлтгэлд тавигдах үндсэн шаардлага, стандартад заасан норматив цагийн багтаамж, сургалтын төлөвлөгөөний цагийн багтаамжид баримжаалах, стандартад заасан багшийн нөөцөд тухайн мэргэжлийн хичээлийг зааж буй багш нарын 70% доошгүй нь үндсэн багш байна гэсэн заалтуудыг хангаж ажиллахад анхаарах
- Хөтөлбөрийн багш нар сургалтын төлбөрөөс орох орлогын зохих хувийг мэдлэг мэргэжлээ дээшлүүлэх, сургалтын орчин, лабораторийн тоног төхөөрөмжийг сайжруулах чиглэлээр захиран зарцуулах эрхтэй байдаг боловч, хөтөлбөрүүдийн орлого хангалтгүй байгаа шалтгааныг судлан, хэрэгжүүлэх

Зөвлөмж:

- Багшийн нөөцийн төлөвлөлт, сонгон шалгаруулалтыг бүрэлдхүүн сургуулийн хөтөлбөрийн багийн саналыг харгалзан СУИС-ийн захирлын тушаал, шийдвэр гаргах
- Тэнхимийн багш нарын судалгааны ажлын чиглэл тодорхой болгон, нөөц хүчин чадлыг нэмэгдүүлэх
- Хөтөлбөрийн багш нарыг хичээлийн жилд орох цагийн ачааллыг анхаарч стандартын дагуу мөрдүүлэх.

6.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Илрэл нотолгоо:

- ✓ Багш нарыг гадаад оронд мэргэжил дээшлүүлэх сургалт, солилцоо, эрдэм шинжилгээ, судалгааны хөтөлбөрт хамруулсан. Алтанчимэг, Хайдав Сингапурт 2014 онд, Алтанчимэг Филиппинд 2017 онд, Амарзаяа 2018 оноос ОХУ-д докторантурт сурч байна.
- ✓ Боловсрол судлал, заах аргазүй, сэтгэл судлалын чиглэлийн их, дээд сургуулийн багшид зориулсан сургалтуудад тогтмол багш нарыг хамруулж байгаа.

- ✓ Багшийн ажлын байран дээрээ мэргэжил ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн орчин бүрдүүлсэн.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багшийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж ажилладаг байдаг.
- Багшийн хөгжлийн төв “Сургах-Суралцахуйн” арга зүйн сургалт, семинар, уулзалт-ярилцлага явуулж, санал зөвлөмжүүдийг гарган, харилцан туршлага солилцох ажлыг зохион байгуулдаг.

Анхаарах асуудал:

- Багшийн цагийн ачаалал болон боловсруулан хэрэгжүүлж буй хичээлийн хөтөлбөрийн тоо, чанарт анхаарах
- CDIO хөтөлбөрийн шинэчлэлийн талаар мэдээлэл болон хэрэгжилтэд анхаарах
- Эчнээ ангийн орлого багшийн орлогын эх үүсвэрт дэмжлэг болж буй хэдий ч ачаалал нэмэгдэхийн хэрээр сургалтын чанарт сөргөөр нөлөөлөхийг анхаарах
- Багшийн хөгжлийг дэмжих, мэргэжлийн багшийн залгамж, хүний нөөцийг бэлтгэхэд анхаарах

Зөвлөмж:

- Олон улсын индекс бүхий эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлүүлсэн өгүүллийн урамшуулал, үнэлэмжийн асуудлыг нэмэгдүүлэх.
- Багш нарын хөгжилд цагийн менежмент чухал үүрэг гүйцэтгэдэг тул өөрийгөө хөгжүүлэх боломж бололцоог гаргах, ажлын ачааллын тэнцвэртэй байдлыг хангах.
- Бүрэлдэхүүн сургууль болон салбар дээрээ багш хөгжлийн төв байгуулж, багш нарыг өөрийгөө хөгжүүлэхэд нь дэмжлэг туслалцаа үзүүлэх.
- CDIO хөтөлбөрийн шинэчлэлийн талаар мэдээлэл өгч, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх
- Багшийн хөгжлийг дэмжих, мэргэжлийн багшийн залгамж, хүний нөөцийг бэлтгэхэд анхаарах, холбогдох санхүүжилтийг төлөвлөх, зарцуулах
- Эрдмийн зэрэгтэй багшийн тоог нэмэгдүүлэх

6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- ✓ Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 288 тоот тогтоолоор “Улсын болон орон нутгийн номын сангийн сан хөмрөгийг байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюулын үед нүүлгэн шилжүүлэх журам”-ыг боловсруулах ажлын хэсэгт А.Алтанцэцэг, Г.Наранцэцэг багш нар ажилласан.
- ✓ Үндэсний номын сангийн мэргэжлийн зөвлөлийн дүрэм боловсруулах ажлын хэсэгт Т.Хайдав ажилласан байна.
- ✓ Номын сан судлалын тэнхимийн багш нар 2015-2020 онд Унгар, Герман, ОХУ-Монгол судлалын холбооны эрдэм шинжилгээний бичигт 5, үндэсний хэмжээний нэр хүнд бүхий сонин, сэтгүүлд 18 илтгэл өгүүлэл хэвлүүлсэн байна.
- ✓ 2017, 2019 онд “Library update” олон улсын зөвлөлгөөн зохион байгуулсан.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Соёл урлагийн боловсролын тогтвортой хөгжил-1, 2 төсөлд 30 сая төг

- СУИС-ийн судалгааны тэргүүлэх чиглэлд хийсэн шинжилгээ \2014-2020\ ,
- СУИС-ийн магистр, докторын судалгааны бүтээлийн ном зүй төсөл 13 сая төг
- “Номын сангийн тайлбар толь” бүтээх ажил 37 сая төгрөгний СУИС-ийн гэрээт ажлуудыг гүйцэтгэсэн байна.
- ШУТС-ийн захиалга төсөл “Цог” сэтгүүлийн цахим мэдээллийн сан 6 сая төгрөгийн санхүүжилтын ажил хийж байна.
- ШУТС-ийн “Соёл урлагийн салбар дахь төрийн бодлогын хэрэгжилт, эрх зүйн орчны шинжилгээ” төсөл 29,5 сая төгрөгөөр гүйцэтгэсэн байна.

Зөвлөмж:

- Багшийн мэргэжил дээшлүүлэх хэрэгцээний судалгааг тогтмол хийх
- Олон улсын нэр хүндтэй сэтгүүлд өгүүлэл бичих арга зүйд суралцах
- Гадаадын хамтын ажиллагаатай сургуулиудтай зочин профессор солилцох, ажлыг өргөжүүлэх, эрдэм шинжилгээний төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж, хамтарч судалгааны ажил хийх

6.4. Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Илрэл нотолгоо:

- Багш нарын өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол хийдэг.
- Багшийн өөрийн үнэлгээнд удирдлагын зүгээс хөндлөнгийн үнэлгээ хийж, сэтгэл ханамжийн судалгааг бүх түвшинд авдаг байдал.
- СУИС-ийн багш нарыг аттестатчлах, багшийн зэрэглэлд тавигдах шаардлагыг дээрх тушаалын 2-р хавсралтад заасан профессор багш ажиллуулах журмын 6-р зүйлийн 3.1.,3.2-ыг ханган ажилладаг байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багшийн үйл ажиллагааны баримт хавтсыг файл бүрдүүлэлтээр 7 төрлөөр хийдэг байна. СУИС-аас жил болгон багшийн хөгжлийн дэвтрээр хангаж сургалтын хуваарь, оюутны ирц үнэлгээг тэмдэглэдэг нь уламжлал болгосон байна.
- Багшийн өөрийн үнэлгээний тайлангийн 1000 оноогоор А- багшийн ажиллагаа, В- Бүтээл, С- Эрдэм шинжилгээ, D- Нийгмийн үйлчилгээ
- Удирдлагаас өгсөн, хугацаатай үүрэг даалгаврын биелэлт, шууд удирдлагын үнэлгээ
- Хамтран ажилладаг хамт олны (газар, алба, салбар, тэнхим) үнэлгээ
- Оюутан, суралцагчийн зүгээс багшлах үйл ажиллагаанд өгсөн үнэлгээ гэх мэт тус тус хөндлөнгөөс үнэлдэг байна.

Зөвлөмж:

- Багшлах бүрэлдэхүүний тоог нэмэгдүүлэх замаар хөгжүүлбэл хөтөлбөрийн чанар, нэр хүнд улам дээшилнэ.

6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

Илрэл нотолгоо:

- ✓ СУИС-ийн хэмжээнд хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтыг хариуцсан мэргэжилтэнтэй. СУИС-ийн захирлын 2022 оны 01-р сарын 21-ны өдрийн А/25 дугаар тушаалаар Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод чанарын баталгаажуулалтын 2022 оны ажлын төлөвлөгөө баталсан байна.
- ✓ Чанарын дотоод баталгаажуулалтын асуудалд сүүлийн 2 жилд нэлээд анхаарал хандуулж, чиглэсэн дүрэм журам, ажлын төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байна.
- ✓ Дотоод чанарын баталгаажуулалт хариуцсан ажилтан нь давхар ажил хавсарч хийдэг байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн явцад өдөр тутам сургалтын алба болон тэнхим хяналт тавьж ажилладаг байна.
- Багшийн аттестачлалыг 2 жил тутам 1 удаа зохион байгуулдаг.
- Номын сан судлал мэргэжлээр төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгааг таван жилээр тогтмол хийдэг.

Анхаарах асуудал:

- Ярилцлага хийх явцад тухайн хариуцсан ажилтан нь саяхан хүлээн авсан бөгөөд уг ажлын талаар сайн мэдэхгүй байгаа байдал ажиглагдсан.

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтын бүтэц, хариуцсан ажилтны ажил үүргийн хуваарийг тодорхой болгох, хэрэгжүүлэх, хяналт тавьж ажиллах
- Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд үнэлгээ хийх, үнэлгээг тогтмолжуулах

7.2. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна.

Илрэл нотолгоо:

- ✓ Номын сан судлал хөтөлбөрөөр төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаа тогтмол хийдэг ба 2008-2013 оны судалгаагаас үзэхэд 90% нь мэргэжлээрээ ажиллаж байна. НСС хөтөлбөрөөр нийт 2450 мэргэжилтэн суралцаж төгссөний 89-90% нь мэргэжлээрээ ажиллаж байна.
- ✓ Хөтөлбөрийг боловсронгуй болгоход оролцогч талуудын саналыг тусгадаг. БСШУСЯ, Соёлын яам, Монголын номын сангуудын консорциум болон Үндэсний номын сан, УБ хотын төв номын сан зэрэг ажил олгогч байгууллагуудтай хамтран хөтөлбөрийг шинэчлэх талаар зөвлөгөөн зохион байгуулж, түүний үр дүнд сургалтын 3 хөтөлбөрийг шинэчилсэн байна.
- ✓ Ажил олгогч, төгсөгчдийн хүрээнд хийсэн уулзалтаар хөтөлбөрийн чанарыг сайн гэж үнэлсэн. Уг уулзалтыг сургууль дээр ажиллах хугацаанд хийсэн.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Номын сан судлал хөтөлбөрөөр төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаа тогтмол хийдэг ба 2008-2013 оны судалгаагаас үзэхэд 90% нь мэргэжлээрээ ажиллаж байна.
- Динамик платформ, uniculture системийг нэвтрүүлсэн нь ажлын ачааллыг хөнгөвчилж, суралцагч тодорхой мэдээллийг нээлттэйгээр ашиглах, сургалтай холбоотой санал хүсэлтээ шуурхай илэрхийлэх боломж бүрджээ.
- Сургалт бүрийн төгсгөлд суралцагчдаас хөтөлбөрийн талаарх санал, асуулга тогтмол авч хэвшжээ. Ингэхдээ сургалтын динамик платформ, Uniculture, google form зэргийг ашигладаг байна.

Анхаарах асуудал:

- Нийгмийн тогтолцоо, зах зээлийн шинж, улс төрийн үзэл баримтлалын шалтгаанаар номын сангийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар бүрэн хангагдахгүй байна.
- Ажлын байрны хэрэгцээ их учир мэргэжлийн бус хүн ажиллах хандлага ихэссэн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлөх боломжтой
- Мэргэжлийн нэр хүндийг өсгөх, төгсөгчдийн карьер өсөлтийг дэмжих зорилгоор эрдэм шинжилгээний хурлыг сүүлийн үед зохион байгуулаагүй.
- Мэргэжлийн хичээл заах үндсэн багшийн тоо хангалтгүй байгаа нь чанарыг бууруулах эрсдэлийг бий болгож байна.

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн үр дүнгийн судалгааг нарийвчлан хийх, судалгааны үр дүнг шийдвэр гаргалтад ашиглах
- Мэргэжлийн нэр хүндийг өсгөх, төгсөгчдийн карьер өсөлтийг дэмжих зорилгоор эрдэм шинжилгээний хурлыг тогтмолжуулж, мэргэжлийн сэтгүүл гаргах
- Хөтөлбөрөөр төгсөгчдийн үндэсний хэл, бичиг, эх бичиг, сурвалж судлал, англи хэл, цахим программын мэдлэг чадварыг нэмэгдүүлэх.

7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- ✓ Номын сан судлал хөтөлбөр нь 65 жилийн түүхтэй.
- ✓ Уг хөтөлбөр нь 2014 онд Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлөөр хөтөлбөрөө магадлуулсан байна.
- ✓ MNS 5323-130:2013 "Номын сан судлал-мэдээлэл" D320400 мэргэжлийн стандарт боловсруулж Стандарт, хэмжил зүйн газраар батлуулсан.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Нийт 2450 мэргэжилтэн суралцаж төгссөний 89-90% нь мэргэжлээрээ ажиллаж байна
- ОХУ-ын Дорнод Сибирийн сургуультай хамтран ажиллаж байна.
- Дотооддоо ижил хөтөлбөрөөр төгсөж буй төгсөгчдөөс илүү ажил олгогчдод болон нийгэмд илүү хүлээн зөвшөөрөгддөг.

Зөвлөмж:

- Номын сан судлал хөтөлбөрт элсэлтийн тоог нэмэгдүүлэх, багшлах бүрэлдэхүүнийг хөгжүүлэх замаар хөтөлбөрийн чанарыг сайжруулах, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг бий болгох

7-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

ДҮГНЭЛТ

Номын сан судлал

Шалгуур	Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангаагүй (0)	Үндэслэл, шалтгаан
1 Шалгуур 1: Хөтөлбөрийн төлөвлөлт	2			
2 Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа	2			
3 Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	2			
4 Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	2			
5 Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	2			
6 Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа	2			
7 Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт	2			
Дүгнэлт	Бүрэн хангасан			

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг Соёл Урлагийн Их Сургуулийн Соёлын сургуулийн “Номын сан судлал” хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН” гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг Нийгмийн шинжлэх ухаан, мэдээлэл, сэтгүүл зүйн чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагч: Б.Гантулга

Шинжээчийн багийн гишүүн: Ч.Мөнх-Эрдэнэ

Шинжээчийн багийн гишүүн: Д.Дэлгэрмаа

НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ, ШААРДЛАГА

Сургуулийн нэр	Соёл Урлагийн Их Сургуулийн Соёлын Сургууль
Хөтөлбөрийн нэр	Номын сан судлал
Хөтөлбөрийн индекс	D032201
ЗӨВЛӨМЖ	
Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт	<ul style="list-style-type: none"> Хөтөлбөрийг боловсруулахад холбогдох эрх зүйн баримт бичгүүдийн үзэл баримтлалтай холбох;
Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> Хөтөлбөрийг хэрэгжүүлж буй тэнхимийн хамт олны үйл ажиллагааг сургуулийн зүгээс сайн дэмжих; Хөтөлбөрийн залгамж холбоог сайжруулан төгсөгчдийг давтан сургах, зэрэг олгох сургалтын хөтөлбөрүүдийг боловсруулан хэрэгжүүлэх; Багшийн цагийн ачаалал болон боловсруулан хэрэгжүүлж буй хичээлийн хөтөлбөрийн тоо, чанарт анхаарч ажиллах; Сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээл нэг бүрийн үнэлгээний арга, хэлбэр нь суралцагчдыг тасралтгүй хөгжихөд хөтлөх боломжийг бүрдүүлэх, хичээл бүрээр явцын болон улирлын үнэлгээний ахиц дэвшлийн анализ хийдэг байх;
Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөөц	<ul style="list-style-type: none"> Шинэ барилга байгууламжтай болтол одоогийн ашиглаж байгаа хичээлийн 3-р байрны хаалганы босгонд хөгжлийн онцлогтой оюутанд зориулсан пандус хийлгэх. Барилгад хүчитгэл хийж угсрах, урсгал засварыг чанартай сайн хийж гүйцэтгүүлэх; Хөтөлбөрийг хэрэгжүүлж буй тэнхимийн үйл ажиллагааг сургуулийг зүгээс сайн дэмжих, эрдэмжилтийн талаар, мөн материаллаг хэрэглэл, орчин нөхцөлийг анхаарах; Суралцагчдын эрүүл мэнд, бие бялдрыг хөгжүүлэх биеийн тамирын хичээл оруулах спортын заал, дасгалын өрөөтэй болох, эсвэл түрээсийн гэрээ байгуулах; Орчин үеийн шаардлагад нийцсэн сургалтын цахим хэрэглүүр, программ хангамжийг нэвтрүүлэн ашиглах;
Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	<ul style="list-style-type: none"> Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжийн урт, дунд, богино хугацааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх, хөтөлбөрийн элсэгч, суралцагчийн хувийг нэмэгдүүлэхэд сургуулийн зүгээс БШУЯ-нд эрэлттэй мэргэжлийн жагсаалтад оруулах; Багшлах бүрэлдэхүүн, төгсөгчид, ажил олгогчдын нөөцийг ашиглан номын сангийн салбар болон, номын санчдын мэргэжлийн үнэлэмж, нэр хүндийг өсгөх, олон нийтэд хандсан контентыг бүтээх замаар элсэгчдийн тоог нэмэгдүүлэх;
Шалгуур 5. Суралцагчдад чиглэсэн үйлчилгээ	<ul style="list-style-type: none"> Суралцагч оюутнуудад зориулсан дэмжлэг, тэтгэлэгт хамрагдах талаар менежмент хийн элсэгчдэд хүссэн мэдээллээ авах боломжийг олгох; Олон нийтийн сүлжээгээр “Номын сан судлал” хөтөлбөрийн талаар болон энэ мэргэжлийн ач холбогдлын талаар илүү сурталчлах; Сурлагын амжилтаар тэргүүлэгч оюутнуудыг бусад оюутны дунд алдаршуулан урамшуулах, гадаадын их дээд сургууль болон ахисан түвшний сургалтад хамруулах; Сургалтын төлбөрийн хөнгөлөлт, дэмжлэг, тэтгэлэгт хамрагдах мэдээллийг нээлттэй байх; Төгсөгчдийн холбоо байгуулж, үйл ажиллагааг идэвхжүүлэх;

Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> • Багш нарын өөрийгөө хөгжүүлэх боломж бололцоог нэмэгдүүлэх, ажлын ачааллын тэнцвэртэй байдлыг хангах; • Багшийн нөөцийн төлөвлөлт, сонгон шалгаруулалтыг бүрэлдэхүүн сургуулийн хөтөлбөрийн багийн саналыг харгалзан СУИС-ийн захирлын тушаал, шийдвэр гаргах; • Багшийн ажлын багшлахуйн чадварыг дээшлүүлэх /хөтөлбөр судлал, суралцагчдын онцлог, ялгаатай байдлын асуудал, мэргэжлийн дидактикийн чиглэлээр багш нар тасралтгүй суралцахад анхаарах/; • Бүрэлдэхүүн сургууль болон салбар дээрээ Багш хөгжлийн төв байгуулж, багш нарыг өөрийгөө хөгжүүлэхэд нь дэмжлэг туслалцаа үзүүлэх;
Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт	<ul style="list-style-type: none"> • Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтын бүтэц, хариуцсан ажилтны ажил үүргийн хуваарийг тодорхой болгох, хэрэгжүүлэх, хяналт тавьж ажиллах; • Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд үнэлгээ хийх, үнэлгээг тогтмолжуулах; • Хөтөлбөрийн үр дүнгийн судалгааг нарийвчлан хийх, судалгааны үр дүнг шийдвэр гаргалтад ашиглах; • Мэргэжлийн нэр хүндийг өсгөх, төгсөгчдийн карьер өсөлтийг дэмжих зорилгоор эрдэм шинжилгээний хурлыг тогтмолжуулж, мэргэжлийн сэтгүүл гаргах; • Хөтөлбөрт элсэлтийг нэмэгдүүлэх, багшлах бүрэлдэхүүний хөгжүүлэх замаар хөтөлбөрийг чанарыг улам сайжруулах;
ШААРДЛАГА	
1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд	<ul style="list-style-type: none"> • Хичээлээр хүрэх үр дүн хөтөлбөрөөр хүрэх үр дүнгийн холбоо хичээлийн стандарт болон хөтөлбөрт тусгаж боловсруулах;
2.2. Сургалтын арга зүй	<ul style="list-style-type: none"> • Сургалтын арга зүйг хэрэгжүүлэх загвар, заавар, зөвлөмж, суралцахуйн болон багшлахуйн арга зүйг баримт бичиг, зөвлөмжид тусган ажиллах;
4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт	<ul style="list-style-type: none"> • Номын сан судлал хөтөлбөрийн талаар маркетингийн тусгай төсөл боловсруулж, хэрэгжүүлэхэд дотоод нөөц боломжийг ашиглах;
5.1. Суралцагч сонгох, элсүүлэх	<ul style="list-style-type: none"> • Оюутан суралцагчдад хичээл болон багшаа сонгох боломжийг бий болгох;
6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого	<ul style="list-style-type: none"> • “Номын сан судлал мэдээлэл” мэргэжилтний стандартад заасан мэргэжлийн тодорхойлолт, төгсөгчдийн мэргэжлийн бэлтгэлд тавигдах үндсэн шаардлага, стандартад заасан норматив цагийн багтаамж, сургалтын төлөвлөгөөний цагийн багтаамжид баримжаалах, стандартад заасан багшийн нөөцөд тухайн мэргэжлийн хичээлийг зааж буй багш нарын 70% доошгүй нь үндсэн багш байна гэсэн заалтуудыг хангаж ажиллахад анхаарах;
7.2. Хөтөлбөрийн үр дүн	<ul style="list-style-type: none"> • Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтын бүтэц, хариуцсан ажилтны ажил үүргийн хуваарийг тодорхой болгох, хэрэгжүүлэх, хяналт тавьж ажиллуулах;

IV. Ярилцлагад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс (Хугацаа: 2022 оны 06 сарын 02 өдөр 14.00-15.00)

№	Нэр	Албан тушаал	Зэрэг цол	Ажилласан жил	Заадаг хичээл
1	Ж.Цэзэн	Тэнхимийн эрхлэгч	ScD	30 гаруй жил	Номзүй судлал, НСМен ба маркетинг, ном хэвлэлийн түүх
2	Т.Хайдав	Гэрээт багш	MA	20 гаруй жил	Номын сангийн фонд, каталоги, Номын сангийн автоматжуулалт, НС
3	А.Алтанчимэг	Ахлах багш	MA	20 гаруй жил	Номын сан судлал, Номын сангийн үйлчилгээ, НС орчны
4	Г.Наранцэцэг	Гэрээт багш	MA	10 гаруй жил	Номын сан судлал, Ном сэлбэн засах, орчны стандарт.
5	В.Түвшинтогтох	Цагийн багш	MA	2-3 жил	Номын сангийн үйлчилгээ, Ерөнхий ном
6	Б.Амарзаяа	Багш	MA	10 жил	Ерөнхий ном зүй, Салбар ном зүй, Гадаад орны ном зүй,
7	В.Ариунаа	Үндсэн ба цагийн багш	MA	3-5 жил	ЕНЗ, СНЗ, Мэргэжлийн англи хэл
8	Ж.Баатарсүрэн	Цагийн багш	MA	3 жил	Цахим номын сан
9	Т.Баярлах	Цагийн багш	MA	5 жил	Төвд хэл
10	Гансүх	Цагийн багш	MA	1 жил	НСангийн үйлчилгээний Менежмент
11	О.Нарантуяа	Цагийн багш	MA	2 жил	Зохиогчийн эрх
12	Д.Оюунбилэг	Үндсэн ба цагийн багш	MA	5 жил	Номын сангийн фонд, номын сангийн
13	Д.Мандах	Цагийн багш	Ph.D	30 гаруй жил	Номын сангийн ня/бо, Судалгааны ажлын аргазүй
14	Л.Тунгалаг	Цагийн багш	MA	30 гаруй жил	Чөлөөт цагийн үйл ажиллагааны үндэс
15	Ш.Оюундэлгэрэх	Цагийн багш	MA	20 гаруй жил	Чөлөөт цагийн үйл ажиллагааны үндэс, Соёлын менежмент

II. Оюутны нэрс (Хугацаа: 2022 оны 06 сарын 02 өдөр 15.00-16.00)

№	Оюутны нэрс	Курс	Сонгосон байдал	Утас
1	Д.Айдана	IV	Орон нутгийн	99706110

2	Б.Бүжинлхам	IV	Орон нутгийн	94754290
3	А.Мягмар-Арвижих	IV	Эрэгтэй	95798910
4	Ө.Цагаан-Охин	IV	Ангийн дарга	94293122
5	Г.Отгонжаргал	II	Хөгжлийн бэрхшээлтэй	95856725
6	Б.Баярмаа	Эчнээ III	УБ хот	96635744
7	Г.Бямбасүрэн	Эчнээ II		89072785
8	М.Бямбацэцэг	Эчнээ II		88919607
9	Д.Золжаргал	Эчнээ II		95726066
10	Н.Отгонжаргал	Эчнээ II		89442635
11	Д.Оюунтуяа	Эчнээ II		99849085
12	Г.Энхчимэг	Эчнээ II		94259111
13	Х.Энхтүвшин	Эчнээ II		88116987

III. Төгсөгчдийн нэрс (Хугацаа: 2022 оны 06 сарын 03 өдөр 11.00-12.00 Цахим)

№	Овог нэрс	Төгссөн он	Байгууллага	Албан тушаал
1	Билэгсайхан	2016	МУУНС	Номын санч
2	Б.Бороо	2016	ДХИС	Номын санч
3	Г.Цэрэндулам	2016	АШУУИС	Номын санч
4	М.Пүрэвсүрэн	2017	МУИС-ийн НС	Номын санч
5	Э.Рэгзэдмаа	2017	МУИС-ийн НС	ЭШФонд-номын санч
6	Э.Сарангэрэл	2017	ДХИС	Номын санч
7	М.Эрдэнэцэцэг	2017	Хобби	Ахлах номын санч
8	Т.Билэгбаяр	2018	МУУНС	Сэтгүүлийн Фонд
9	Нацагням	2018	Философийн хүрээлэнгийн НС	Номын санч
10	К.Тамаша	2018	ХНО	"Их мэдэх" тэнхмийн Номын санч
11	А.Хонгорзул	2018	МУУНС	Карт бүртгэл, солилцооны номын санч
12	Б.Сумъяажаргал	2019	МУИС-ийн НС	Номын санч
13	С.Бямбарагчаа	2019	ДХИС	Цахим уншлагын номын санч
14	Д.Сувдмаа	2019	МУБИС	Номын санч
15	З.Билгүүн	2019	ДХИС	Номын санч
16	Т.Ганцэцэг	2020	Ач АУИС	Номын санч
17	Т.Мянганжадамба	2020	ДХИС	Каталогич
18	А.Халиун	2020	СУИС, СС	Номын санч
19	Э.Алтанзул	2021	УБХНТНС	Угтах үйлчилгээний номын санч
20	Ж.Тунгалаг	2021	ЧД.ХНомын өргөө	Номын санч
21	Г.Пүрэвмаа	2021	Глобал удирдагч дээд сургууль	Номын санч
22	Г.Энхжин	2021	Мандах ИС	Оюутан хариуцсан мэргэжилтэн

IV. Ажил олгогчдын нэрс (Хугацаа: 2022 оны 06 сарын 03 өдөр 12.00-13.00 Цахим)

№	Овог нэрс	Байгууллага	Албан тушаал
---	-----------	-------------	--------------

1	Б.Тунгалаг	МУУНС	Сан хөмрөг хадгаламжийн хэлтсийн дарга
2	Б.Амарзаяа	ХТНС	Уншлага үйлчилгээний хэлтсийн дарга
3	О.Долгорсүрэн	УБХНТНС	Олон нийтэд үйлчлэх тасгийн дарга
4	З.Төгсжаргал	УБХНТНС	Ном бүрдүүлэх, тусгай үйлчилгээний тасгийн эрхлэгч
5	Б.Алтынгүл	Баян-өлгий АННС	захирал
6	М.Лхагважав	Увс аймаг ННС	захирал
7	Б.Мөнгөнтуяа	Булган АННС	дарга
8	Г.Нямцэнд	Дархан ТНС	Ахлах номын санч
9	Т.Өнөрцэцэг	Төв аймаг ННС	Хүний нөөцийн мэргэжилтэн
10	А.Уранчимэг	Орхон СУГазрын	дарга
11	С.Энхтогтох	Өвөрхангай АННС	сан хөмрөгч
12	Ж.Баатарсүрэн	МУБИС-ийн төв номын сан	Номын сангийн захирал
13	З.Баярцэнгэл	АШУҮИС-ийн төв номын сан	захирал
14	Ц.Мягмарсүрэн	ҮБХИС-ийн төв номын сан	захирал
15	О.Нарантуяа	МУИС-ийн номын сан	Ахлах номын санч
16	Д.Нямбазар	ХААИС -ийн төв номын сан	захирал
17	Б.Эрдэнэцэцэг	ДХИС-ийн төв номын сан	Ахлах номын санч

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

/албан бичгийг оруулах/



ҮI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан (огноо)
 [Мэргэжлийн зөвлөлийн хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

Зөвлөмж /Recommendations/

ҮII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Магадлан итгэмжлэх комиссын хуралдаан (огноо)
 [Магадлан итгэмжлэх комиссын хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

Зөвлөмж /Recommendations/